



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/15

Дэлгэрхаан сум

Аймгийн арслан цолтой бөхчүүдэд
хүндэтгэл үзүүлэх зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлын 3.1 заалт болох төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих ажлын хүрээнд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ивээл дор зохион байгуулагдаж байгаа “Аймгийн арслан” цолтой бөхчүүдэд хүндэтгэл үзүүлэх зардалд 1,000,000 (нэг сая) төгрөгийг зарцуулсугай.

2.Аймгийн арслангуудад хүндэтгэл үзүүлэх 1,000,000 (нэг сая) төгрөгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Урангоо), нягтлан бодогч (О.Анхцэцэг)-т зөвшөөрсүгэй.

ДАРГА



Б.ЭНХ-АМГАЛАН



26/11

Stop no Yes
بسم و بسم لا بسم

[illegible][illegible][illegible]

19. ۱۱ - سردی - ہیئتتصویری

